



I–IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 13



Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар, зарлага 6.6 хувиар өслөө


Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 9 сард 2449.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 534.5 (27.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 421.9 (28.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөгөөр, сараар



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 оны эхний 9 сард 2466.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 152.1 (6.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 103.5 (6.4%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 68.6 (31.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧИД, төрлөөр, 2021 оны эхний 9 сарын байдлаар



Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний 9 сард 458.6 мянган хүн тэтгэвэр авсны 76.3 хувь нь өндөр настны тэтгэвэр авагчид, 15.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагчид, 8.7 хувь нь бусад (тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр) тэтгэвэр авагчид байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2021 оны эхний 9 сард 19263 хүнд 39.4 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 3475 (22.0%) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 1710.2 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 9 сард давхардсан тоогоор 2.4 сая хүнд 1480.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 41.2 (1.8%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 357.5 (31.8%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 288.0 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100.0 мянган төгрөгөөр 2020 оны 4 дүгээр сараас 2022 оны 1 дүгээр сар хүртэл нэмэгдүүлж олгохоор шийдвэрлэсэн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо 31.4 (2.7%) мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 354.3 тэрбум (48.3%) төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX	<u>2021 I-IX</u> <u>2020 I-IX</u>
	хүн				хувь
Бүгд	1 848 167	2 130 129	2 313 210	2 354 396	101.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	404 720	400 363	411 662	388 965	94.5
Тэтгэвэр	57 687	56 982	56 744	65 297	115.1
Тэтгэмж	56 944	94 520	110 058	114 396	103.9
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	290 089	248 861	244 860	209 272	85.5
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	215 318	217 073	224 956	238 604	106.1
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	912 000	979 965	1 177 009	1 208 418	102.7
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	86 105	106 569	86 956	94 317	108.5
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2 453	2 448	2 441	85	3.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	17 080	18 948	13 913	8 327	59.9
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	82 157	270 023	254 945	265 884	104.3
Насны хишиг	128 334	134 384	140 951	149 401	106.0
Цаатан иргэний тэтгэмж	-	356	377	395	104.8

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны эхний 9 сард 65.3 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 8.6 (15.1%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 21.9 (18.8%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 70.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 23.1 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 6.4 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 9 сард 114.4 мянган хүн хамрагдсаны 53.2 хувь нь асаргааны тэтгэмжид, 46.8 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 9 сард 76.4 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 5.6 (7.9%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 1087.6 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 оны эхний 9 сард олгожээ.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал

Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан

Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч

Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр

Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.



Эх үүсвэр

Нийгмийн даатгалын ерөнхий газар,
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 1 дүгээр сарын 14

Нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын
Нийгмийн статистикийн хэлтсийн
статистикч Э.Ариунчимэг
Утас : (976-51)-263966

